



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/436

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6, 46.3, Засгийн газрын 2021 оны "Журам батлах тухай" 160 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны "Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай" 124 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны "Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай" А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан "Хоггүй Хөвсгөл" төсөл хэрэгжүүлж эхлүүлэх бараа нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202312036 дугаартай тендерт 82,680,500 (Наян хоёр сая зургаан зуун наян мянга таван зуун) төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Жангас тайга" ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. "Жангас тайга" ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, нийлүүлэх барааны чанар байдал, гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий "Захиалагчийн төлөөлөгч"-өөр Байгаль орчин, аялал жуучлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Мөнхжаргал)-ийг томилж, бараа, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: П.Мөнхжаргал (Байгаль орчин, аялал жуучлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ажлын хэсгийн гишүүд: Ё.Батсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуучлал, уул уурхайн бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн)

Дамдинбазар ("Жангас Тайга" ХХК-ийн менежер)

А.Энхжаргал (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын нутгийн захиргааны байгууллагын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Н.Болоржаргал (Байгаль орчин, аялал жуучлалын газрын орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн)

3. "Хоггүй Хөвсгөл" төсөл хэрэгжүүлж эхлүүлэх бараа нийлүүлэх гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, барааг (үйлчилгээг) хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын йүр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон орон нутгийн архивт шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (П.Мөнхжаргал)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт

d/захирамж
671.015382

оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, бараа (үйлчилгээ) хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон орон нутгийн архивт шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Х.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ

